БАТЛАВ.
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Т.БАДРАЛ

2016 оны ..... дугаар сарын .......-ний өдөр

## АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Зорилго:** Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад авлига, хүнд суртал үүсэх нөхцөл, эрсдлийг бууруулж, авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, бэхжүүлэх, олон нийтийн эрх ашгийг дээдэлж, албан хаагчдыг авлигаас ангид байлгахад оршино.

| Д/д | Үйл ажиллагааны чиглэл | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Үзүүлэлт | | Хариуцах эзэн | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Шаардагдах санхүүгийн нөөц | Хугацаа | | |
| **Нэг. БАЙГУУЛЛАГААС ХҮЛЭЭХ НИЙТЛЭГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ /Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа/** | | | | | | |
| 1. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийгхангах | 1.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, сургалт зохион байгуулах, яриа таниулга хийх, цахим хуудас, хэвлэмэл материал тараах, албан хаагчдын дунд АХА тэмцээн зохион байгуулах | - | Тухай бүр | Д.Мөнхжаргал Б.Саранцэцэг | Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сайжирна. |
| | | 1.2. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн хэвлэмэл материал, гарын авлага, зурагт хуудас, сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх | - | Тогтмол | Д.Мөнхжаргал Б.Саранцэцэг | |
| | | 1.3. Авлигатай тэмцэх газрын цахим хуудсыг Онцгой байдлын ерөнхий газрын цахимтай холбон мэдээллээр ханган ажиллах | - | Тогтмол | Д.Мөнхжаргал Б.Саранцэцэг Д.Отгонболд | |
| 2. | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж | 2.1. Байгууллагын үйл ажиллагаа, шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох боломжийг бүрдүүлэх | - | Тухай бүр | Л.Өлзийбаяр Д.Отгонболд | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох | 2.2. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт гаргаж цахим хуудсанд байршуулах | - | Тухай бүр | Х.Батцэцэг Д.Отгонболд | хэрэгжилт хангагдана. |
| | | 2.3. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ил, тод нээлттэй байлгах, иргэдийн хэрэгцээ хангахуйц мэдээллийг байгууллагын самбарт байрлуулах | - | Тухай бүр | Д.Базаррагчаа Д.Отгонболд | |
| 3. | Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах | 3.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хийх шалгалтын төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах | - | Тухай бүр | Д.Жаргалмөнх Д.Отгонболд | Дотоод хяналт, шалгалт сайжирч, байгууллагын үйл ажиллагаа шуурхай болж, албан хаагчдын шударга байдал дээшилнэ. |
| | | 3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс төлөвлөгөөт бус шалгалт хийж, хийсэн ажил болон шийдвэрийн талаар цахим хуудсаар мэдээлэх. | - | Тухай бүр | Д.Жаргалмөнх Д.Отгонболд | |
| | | 1.3. Хяналт, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх | - | Тухай бүр | Д.Жаргалмөнх Д.Отгонболд | |
| 4. | Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох | 4.1. Албан хаагч нэг бүрийн ажлын чиг үүрэг, батлагдсан ажлын байрны тодорхойлолтыг мөрдүүлэх | - | Тухай бүр | Л.Болдбаатар Г.Цацрал | Албан хаагчийн ажил үүргийн хуваарь тодорхой болж ажлын бүтээмж сайжирна. |
| | | 4.2. Хариуцсан ажил үүргийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох | - | Тухай бүр | Газар, хэлтэс | |
| 5. | Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах | 5.1. Төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнтэй хамтарч ажиллах | - | Тухай бүр | Б.Уганбаяр Д.Мөнхжаргал Б.Саранцэцэг | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, олон нийтийг мэдээллээр хангана. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6. | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах. уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх | 6.1. Эрх бүхий албан тушаалтнуудын гүйцэтгэх чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг нарийвчлан тодорхойлох | - | Тухай бүр | Л.Болдбаатар Г.Цацрал Б.Саранцэцэг | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах үйл ажиллагаа сайжирна. |
| | | 6.2. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдах | - | Тухай бүр | Л.Болдбаатар Г.Цацрал Д.Мөнхжаргал Б.Саранцэцэг | |
| | | 6.3. Эрх бүхий албан тушаалтнуудад сургалт зохион байгуулах, тэдгээр албан тушаалтнуудын үйл ажиллагааг үнэлэх | - | Тухай бүр | Л.Болдбаатар Г.Цацрал Д.Мөнхжаргал Б.Саранцэцэг | |
| 7. | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх | 7.1.Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгах | - | Тухай бүр | Д.Жаргалмөнх Б.Батболд Д.Эрдэнэбат | Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны дотоод хяналт сайжирч, албан хаагчдын албандаа хандах хандлага, хариуцлагын тогтолцоо бэхжинэ. |
| | | 7.2.Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцлийг тодорхой болгох, мэдээ, мэдээллийг сурталчлах ажлыг зохион байгуулах | - | Тухай бүр | Д.Жаргалмөнх Б.Батболд Д.Эрдэнэбат | |
| | | 7.3. Сонирхлын зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд мэдэгдэл гаргах үүргийг тайлбарлан өгч, урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/ өгөх | - | Тухай бүр | Д.Жаргалмөнх Б.Батболд Д.Эрдэнэбат | |
| | | 7.4. Ёс зүйн дүрмийн хэрэгжилт, ёс зүйн албаны дүгнэлт шийдвэрийг тухай бүр хамт олонд мэдээлж хэвших | - | Тухай бүр | Д.Жаргалмөнх Б.Батболд Д.Эрдэнэбат | |
| | | 7.5. Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх хуулийн шаардлагыг хэрэгжүүлэх | - | Тухай бүр | Д.Жаргалмөнх Б.Батболд Д.Эрдэнэбат | |
| 8. | Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх | 8.1. Албан хаагчдын зүгээс хуулиар зөвшөөрөгдсөн давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгож бүртгэлжүүлэх | - | Тухай бүр | Х.Батцэцэг Д.Отгонболд | Албан хаагчдын нийгмийн баталгаа сайжирна. |
| 9. | Байгууллагын удирдлагаас гаргаж буй | 9.1.Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлж байгууллагын цахим хуудсанд мэдээллийг тухай бүр байршуулж | - | Тухай бүр | Д.Чулуунцэцэг Д.Отгонболд | Хуулийн хэрэгжилт хангагдана |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах | хэвших | | | | |
| 10. | Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх. зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах | 10.1. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, санал, хүсэлт бүрийг хүлээн авч, бүртгэн, мэдээллийн сан бүрдүүлэх | - | Тухай бүр | Д.Мөнхжаргал Н.Болормаа | Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт хангагдана. |
| | | 10.2.Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт мэдээллийг шийдвэрлэх, цаг хугаанд нь хариу хүргүүлэх | - | Тухай бүр | Д.Мөнхжаргал | |
| | | 10.3. Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах албан тушаалтны нэр, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах | - | Тухай бүр | Д.Мөнхжаргал Д.Отгонболд | |
| 11. | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах | 11.1. Авлигад өртөх эрсдэлтэй албан тушаалын жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх | - | Тухай бүр | Д.Мөнхжаргал Х.Батцэцэг | Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сайжирна |
| | | 11.2. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх | - | Тухай бүр | Д.Мөнхжаргал | |
| 12. | Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэх | 12.1. Алба хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг нэгтгэн, хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх | - | Тухай бүр | Д.Мөнхжаргал Б.Саранцэцэг | Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт хангагдана |
| | | 12.2. Алба хаагчдын мэдүүлсэн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэгт хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах | - | Тухай бүр | Д.Мөнхжаргал Б.Саранцэцэг | |
| | | 12.3.Шинээр томилогдох, хөрөнгөнд их хэмжээний өөрчлөлт орсон алба хаагчдаас тухай бүр мэдүүлгийг гаргуулан авч бүртгэл хөтлөн цахим санд оруулах, гүүнд хяналт тавих | - | Тухай бүр | Д.Мөнхжаргал Б.Саранцэцэг | |
| ХОЁР. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ САНАЛ, САНААЧИЛГА | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 13. | Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх | 13.1. Онцгой байдлын ерөнхий газраас авлигын эсрэг үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг боловсруулж батлуулах, төв орон нутагт хүргүүлж, биелэлтийн хэрэгжилтийг гаргуулж хэвших | - | 2 дугаар сар | Д.Мөнхжаргал Б.Саранцэцэг | Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт хангагдана |
| | | 13.2. 2016 оны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний тайланг нэгтгэж, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд Авлигатай тэмцэх газар хүргүүлэх | - | 11 дүгээр сар | Д.Мөнхжаргал Б.Саранцэцэг | |
| | | 13.3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололтыг бичих, тайланд тусгах | - | Тухай бүр | Д.Мөнхжаргал Б.Саранцэцэг | |
| 14. | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлтыг нэмэгдүүлэх | 14.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилгыг дэмжин оролцох | - | Тухай бүр | Д.Мөнхжаргал | Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт хангагдана |
| | | 14.2. Удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, санаачилгыг дэмжих зорилгоор авлигаас ангид байх амлалтын дэвтэр аялуулах | - | Тухай бүр | Д.Мөнхжаргал | |
| 15. | Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх | 15.1. Ажлын байрны шаардлагыг бүрэн ханган ажиллаж байгаа алба хаагч, ажилтныг тогтвортой ажиллах, дэвших боломжоор хангаж, төрийн албаны чадахуйн (мерит) тогтолцоог төлөвшүүлэх; | - | Тухай бүр | Л.Болдбаатар Г.Цацрал | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгоно. |
| | | 15.2. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авсан арга хэмжээ | - | Тухай бүр | Л.Болдбаатар Г.Цацрал | |
| ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ | | | | | | |
| 16. | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах | 16.1. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам, сул орон тооны зар, сонгон шалгаруулалт явуулах талаарх мэдээлэл, удирдлагын ил тод байдлыг хангах болон албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга | - | Тухай бүр | Б.Дөвшин | Хүний нөөцийг ил тод байдлаар шударгаар бүрдүүлж, мэргэжлийн чадварлаг алба |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээний ил тод, нээлттэй байдлыг хангах Цахим хэлбэрээр явуулах үйлчилгээнүүд тогтсон байх /бүртгэл, маягт хуудас бөглөх, сонгон шалгаруулалт, хэлэлцүүлэг, санал авах/, | | | | хаагч нар бүрэлдүүлнэ. |
| 17. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах | 17.1. 2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудасанд байршуулан олон нийтэд мэдээлэх, тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, 2015 оны худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт зэргийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулах | - | Тухай бүр | Д.Болорцэцэг | Төлөвлөгөө, гүйцэтгэлд тулгуурлах, Аудитын байгууллагаас хийсэн тайлан, дүгнэлттэй тулгалт хийн үнэлгээ хийх, Үнэлгээний хороо байгуулсан шийдвэрт үндэслэн үнэлэх боломж нээлттэй болно. |
| | | 17.2. Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх | - | Тухай бүр | Д.Болорцэцэг | |
| | | 17.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулах | - | Тухай бүр | Д.Болорцэцэг | |
| | | 17.4. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх | - | Тухай бүр | Д.Болорцэцэг | |
| ДӨРӨВ.ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ | | | | | | |
| 18. | Шилэн дансны тухай хууль, тогтоомжид нийцүүлэн ажиллах, цахим хуудсаар мэдээллийг цаг тухайд нь мэдээлэх | 18.1. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, цаг тухайд нь тайлагнах, мэдээллийг ил тод болгох | - | Тухай бүр | Н.Найданболд | Хуулийн хэрэгжилт хангагдаж, нээлттэй ил тод байдлыг хангана. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 19. | Төсвийн орлого. түүний зарцуулалт. гадаадын зээл. тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх | 19.1. 2016 оны төсөв, 2015 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны төсвийн төсөл, 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2016 оны төсөвт орсон өөрчлөлт/ ороогүй бол мэдээллэх/, төсвийн орлого бүрдүүлэлтийн мэдээлэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт зэргийг хуульд заасан хугацаанд цахим хуудасанд байршуулах | - | Тухай бүр | Н.Найданболд | Хуулийн хэрэгжилт хангагдаж, нээлттэй ил тод байдлыг хангана. |
| | | 19.2. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудсанд байршуулах | - | Тухай бүр | Н.Найданболд | |
| 20. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа. ажил. үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах | 20.1. Бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарыг цахим хуудас. хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх | - | Тухай бүр | Д.Болорцэцэг | Хуулийн хэрэгжилт хангагдаж, нээлттэй ил тод байдлыг хангана. |
| | | 20.2.Сонгон шалгаруулалт. тендерийн үнэлгээний хороонд сонирхлын зөрчилгүй хөндлөнгийн төлөөлөл /комисс, оролцогч этгээдүүдийн талд хамааралгүй/-ийг оролцуулсан байх | - | Тухай бүр | Д.Болорцэцэг | |

ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА,
ОНЦГОЙ БАЙДЛЫН ХУРАНДАА Л.БОЛДБААТАР

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ОНЦГОЙ БАЙДЛЫН АХМАД Б.САРАНЦЭЦЭГ